



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/312

Ховд

Авто зам байгуулах зурвас газрыг тогтоох тухай

Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2.1 дэх заалтад “Ховд хот дотор 10 км хатуу хучилттай авто зам барина” гэсэн заалтын дагуу тус авто замын трассыг баталж, зураг төсвийг өөрчлөн гүйцэтгэсний дагуу авто зам байгуулах зурвас газрыг авто замын тэнхлэгээс хоёр тийш тус бүр 30 метрт тогтоосугай. Үүнд:

-Жаргалант сумын цэвэрлэх байгууламжийн 4 замын уулзвараас Улаан богочийн пост чиглэлийн 0.482 км авто замын өөрчлөлт.

2.Дээрх зурвас газрыг кадастрын бүртгэлд бүртгэх, барилгын ажилд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д, Авто замын зурвас газрыг зохистой ашиглаж ажиллахыг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/ нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ - д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ